

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2020 ОНЫ 10 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

Багануур дүүрэг

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1.		<p>Паркийн цахилгаан хангамжийн зураг төслийг гүйцэтгэгч “Мон-Энержи Консалт” ХХК нь 51/2020/87 тоот дугаартай Техникийн нөхцөл болон цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах №2020/Ц-61 дугаартай даалгаврын дагуу ЦДӨХАШ-ын урьдчилсан трассын шугамын зургийг боловсруулж, ЦДҮС ТӨХК-тай зөвшилцөн зураг төсөлд нэмэлт өөрчлөлт оруулж байна.</p> <p>Мөн гүйцэтгэгч байгууллага нь зургийн ажлын дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний Зүүн өмнөд бүсийн салбарын ТӨХК-ийн холбогдох инженер техникийн ажилчид, паркийн Ахлах мэргэжилтэнтэй 2020 оны 10 дугаар 28-ны өдөр гурвалсан уулзалт хийж 220/110/35 кВ-ын Багануур дэд станц дээр очиж шинээр холбогдох дэд станцын гаргалгаа болон удирдлага тоноглолыг байршуулах талаар зөвшилцөн хэмжилтийн ажлыг гүйцэтгэв.</p>	100%
2.	<p align="center">БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл</p>	<p>Барилга хот байгуулалтын яамны инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Мөнхбаатар, эрчим хүч хариуцсан инженер Бадамсүрэн, БҮТП-ийн дарга Ч.Элбэгсайхан, маркетинг олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн Д.Оюунсүрэн нар оролцсон уулзалтыг БХБЯ дээр зохион байгуулж, 2021 онд паркийн дэд бүтэц болон нийтийн барилга байгууламжинд шаардлагатай хөрөнгө оруулалтын талаар танилцуулга хийж, яамны зүгээс бодлого төлөвлөлтийн газар, хөрөнгө оруулалтын газраараа дамжуулан судалж дахин ярилцахаар санал солилцсон. Мөн паркийн цахилгаан хангамжийн зураг төслийг захиалагч болон гүйцэтгэгч талаас яаралтай дуусгаж, холбогдох байгуулагуудын хяналт магадлангаар баталгаажуулж, хүлээлгэж өгөх талаар санал солилцож хүсэлт тавьсан.</p>	100%
3.		<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батбаясгалан даргатай 10 дугаар сарын 05-ны өдөр уулзалт зохион байгуулж НЗД-ын зөвлөлийн хурлаар оруулах асуудлын талаар хэлэлцэж санал солилцсон.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлуудын шийдвэрийн төслийн саналыг боловсруулан нэмэлт өөрчлөлт оруулж байна.</p>	100%
4.		<p>Уурхайн дэд бүтцийг ашиглах талаар Эрдэнэс Монгол ХХК-ийн Нэгдсэн удирдлага хариуцсан дэд захирал, Багануур ХК-ийн ТУЗ-ийн дарга Ц.Батсайхан, стратеги төлөвлөлт хариуцсан дэд захирал Э.Дөлгөөн, паркийн удирдлага нар оролцсон уулзалтыг 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж, ЭХЯ-наас 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдөр олгосон Б1/2020/87 техникийн нөхцөлийн хувьд</p>	100%

		уурхайн дэд бүтцийг ашиглах асуудлыг нарийвчлан тооцоолж, Багануур ХК-ийн удирдлагатай хамтран ажиллахаар санал солилцов. Мөн Багануур ХК-ийн Техникийн бодлого эрхэлсэн дэд захирал П.Эрдэнэцогттой паркийн мэргэжилтнүүд 2020.10.23-ны өдөр уулзалт зохион байгуулж, 2020.09.28-ны өдрийн Мэдээлэл авах тухай 179 дугаартай албан бичгийн дагуу мэдээллийг гаргаж өгөх холбогдох мэргэжилтнүүдтэй уулзсан.	
5.		Паркийн Хүнд үйлдвэрлэлийн бүсэд байгуулах боломжтой Нүүрс хийжүүлэх технологийг суурин газарт нэвтрүүлэх төсөлтэй танилцаж дүгнэлт гаргасан. Нүүрс хийжүүлэх технологийг нэвтрүүлснээр түлшийг хэмнээд зогсохгүй экологи байгаль орчны бохирдлоос үүдэн гарах хүн амын эрүүл мэндэд үзүүлдэг сөрөг нөлөөлөл багасч, сум суурин газрын айл өрх байнгын халаалтын горимд шилжиж, утаагүй эко технологи нутагших боломж бүрдэнэ.	100%
6.	Гүйцэтгэлийн зорилт 3.1.1	“Кластер ба инновацийн тухай ойлголт, хэрэгжүүлэх арга зам” сэдэвт зөвлөгөөний хөтөлбөрийг боловсруулж бэлтгэл ажлыг хангаад байна. Зөвлөгөөнийг 11 дүгээр сарын 06-ны өдөр Багануурт зохион байгуулахаар товлосон боловч нийслэлийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгтэй давхцсан тул хугацааг түр хойшлуулаад байна.	100%
7.	Хамтын ажиллагаа	Паркийн үйл ажиллагаагаар холбогдох Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран ажиллах уулзалтыг 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулав. Уулзалтад БШУЯ-ны газрын дарга нар, паркийн удирдлага холбогдох мэргэжилтнүүдийн хамт оролцон харилцан мэдээлэл солилцож, цаашид хамтран ажиллах хамтын ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн, паркийг бодлогын хүрээнд дэмжиж ажиллахаар болсон. БОАЖЯ-тай хамтран ажиллах уулзалтыг 10 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтаар БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга, паркийн холбогдох мэргэжилтнүүд оролцон харилцан мэдээлэл солилцож, цаашид хамтран ажиллах хамтын ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцсэн.	100%
8.	Гүйцэтгэлийн зорилт 2.1.2	Компост бордоог туршсан “Багануур тохижилт” байгууллагын төв магистраль автозам дагуух моднуудын ургалтын явцад хяналт тавив.	100%
9.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан ба “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2020 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар хариутай 7, хариугүй 10 бичиг нийт 17 албан бичиг ирсэн ба шийдвэрлэлт 94,29 хувьтай байна. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас ААНБ-уудад хариугүй 16 албан бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна. Мөн 10 дугаар сарын 01-ний өдөр 2 албан хаагчийн ээлжийн амралт, 10 дугаар сарын 05-ны өдөр 5 хоногийн сургалтад хамрагдсан 1 ажилтны мэдээлэл, 10 дугаар сарын 30-ны өдөр 2 албан хаагчийн ээлжийн амралтыг ERP системд оруулан бүртгэсэн.	100%

10.	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.1	baganuur-itp.mn цахим хуудасны хөгжүүлэлт, баяжилтыг тогтмол хийж, корона вирустэй холбоотой цаг үеийн мэдээг тасралтгүй хүргэж байна.	100%
11.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бусад үүрэгт ажлыг хугацаанд нь гүйцэтгэж ажилласан. Шилэн дансанд мэдээллийг агуулга, стандартын дагуу байршуулан, санхүүгийн 03 дугаар улирлын тайланг илгээсэн.	100%
НЭМЭЛТ АЖИЛ			
12.	Нийслэлийн Засаг даргын А/108 дугаар захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гарагт zendmaal@gmail.com цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна.		100%
13.	Нийслэлийн Засаг даргын А/168 дугаар захирамжийн биелэлтийг 14 хоног бүр гарган НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.		100%
14.	Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах үүднээс байгууллагын зардлаар Revit 5 хоногийн сургалтад 10 дугаар сарын 05-09-ний хооронд паркийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженерийг хамруулав.		100%
15.	НЗДТГ-ын Нийслэлийн инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч М. Халиунбатад паркийн өнөөгийн байдлын талаар 186 дугаартай албан бичгийг 10 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлсэн.		100%
16.	Орон нутгийн сонгууль болохтой холбогдуулан 10 дугаар сарын 06-ны өдөр Багануур дүүргийн МАН-аас нэр дэвшигчид аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүдтэй зохион байгуулсан нэгдсэн уулзалтад паркийн удирдлага, ахлах мэргэжилтнүүд оролцсон.		100%
17.	2020 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Биологийн хүрээлэнгийн захирал Оюунбилэг доктортой ховор эмийн ургамлын плантаци байгуулах чиглэлээр уулзалт зохион байгуулж, ШУТИС, МУИС, ХААИС, ШАУИС, УХЭШХ-тэй хамтран ажиллаж байгаа мэдээллийг хүргэн, цаашид биологийн хүрээлэнтэй хамтын ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэхээр тогтов.		100%
18.	Мэдээлэл технологийн үндэсний паркаас зохион байгуулсан "Мэдээлэл технологийн хүний нөөцийн хөгжил" сэдэвт сургалтад 10 дугаар сарын 08-ны өдөр Захиргааны Ахлах мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхзаяа хамрагдав.		100%
19.	УУХҮЯ дээр 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан аж үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагуудад зөвшөөрөл олгох журмын төслийн хэлэлцүүлэгт УУХҮЯ, ХХААХҮЯ, БШУЯ, ШУТИС, МУИС, ТББ, барилга болон ноос, ноолуур боловсруулах үйлдвэр, Налайхын хог хаягдал боловсруулах үйлдвэр зэрэг байгууллагуудаас оролцов. Паркийн зүгээс эрдэм шинжилгээ, судалгааны төвийн конструктор инженер оролцож журмын төсөлд саналаа өгөв.		100%
20.	10 дугаар сарын 09-ний өдөр МУИС-тай уулзалт Шар сүүг дахин боловсруулж шим тэжээлийн болон эмчилгээний зориулалттай бүтээгдэхүүн гаргах инновацийн үйлдвэрийн төслийн судалгааны ажилтай танилцаж, хамтран хэрэгжүүлэхээр 10 дугаар сарын 21-ний өдөр МУИС-ийн багш нартай дахин уулзалт зохион байгуулан уг инновацийн үйлдвэрийн төсөл боловсруулж хэрэгжүүлэх хамтын ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулахаар тогтож, төлөвлөгөөг боловсруулан 10 дугаар сарын 27-ны өдөр МУИС-ийн холбогдох багшийн цахим шуудан руу батлуулахаар илгээсэн. МУИС-ийн зүгээс төлөвлөгөөг батлахаар бэлтгэж байна.		100%

21.	Багануур дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/326 дугаар захирамжийн дагуу "Сүрьеэгүй хамт олон" аяны хүрээнд баталсан төлөвлөгөөний дагуу Сүрьеэ, ковид-19, ТТӨ, ХБӨ-ийн талаарх сургалтыг 10 дугаар сарын 30-ны өдөр дүүргийн ЭМТ-өөс авсан.	100%
22.	НЗДТГ-аас 10 дугаар сарын 09-ний өдөр ирүүлсэн 03/5819 дугаартай албан бичгийн дагуу Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын албан хаагчдын судалгааг гаргаж, 10 дугаар сарын 12-ны өдрийн 188 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хүний нөөцийн удирдлагын тасагт хүргүүлэв.	100%
23.	Багануур дүүргийн ЗДТГ-аас 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн 04/76 дугаартай албан бичгийн дагуу Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтны хүний нөөцийн судалгааг гаргаж, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 189 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	100%
24.	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт зориулан байгууллагаас хувцас хэрэглэлээр хангаж, 2020 оны 10 дугаар сарын 21,23,27-ны өдөр урьдчилсан сэргийлэх үзлэгт штабын бүрэлдэхүүн хамрагдсан. 10 дугаар сарын 29-ний өдөр Багануур дүүргийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын нэгдсэн үзлэгт 65 байгууллагууд Нацагдоржийн талбай дээр цугларан ёслолын жагсаал хийж, үүргэвчний бүрэн байдлыг шалгуулсан ба Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын штабын бүрэлдэхүүн амжилттай оролцсон.	100%
25.	Багануур дүүргийн ГБХЗХХ-ээс 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 154 дугаартай албан бичгийн дагуу байгууллагын ГБХЗХХ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг 10 дугаар сарын 21-ний өдрийн 193 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100%
26.	НЗДТГ-аас 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн 08/5896 дугаартай албан бичгийн дагуу "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд гадаадаас ажиллах хүчин авахаар гэрээ хэлэлцээр байгуулаагүй талаарх мэдээллийг "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 192 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100%
27.	2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр дүүргийн ЗДТГ-ын 302 тоотод Европын Холбооны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын хамтын ажиллагааны хэлтсийн төслийн мэргэжилтэн Евгения, холбогдох мэргэжилтнүүд, ЖДҮ-ийн удирдлагууд нийт 20 хүн хамрагдсан уулзалтад паркийн Кластер инженер хамрагдаж шаардлагатай мэдээллийг авсан.	100%
28.	Багахангай дүүргийн Хөнгөн үйлдвэр технологийн паркаас 2020.10.23-ны өдөр туршлага солилцохоор уулзалт зохион байгуулав.	100%
29.	НЗДТГ-аас 10 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн 03/6091 дугаартай албан бичгийн дагуу "Дэлхийн алхалтын өдөр"-ийг улс орон даяар зохион байгуулж байгаатай холбогдуулан байгууллагын ажилтан албан хаагч нарын дунд "Хэн хамгийн олон алхам алхах вэ?" бичил уралдааныг хамт олны дунд зохион байгуулж, өдөр бүр ажилдаа явахдаа, бусад байгууллагууд руу очихдоо, чөлөөт цагаараа байнга алхаж байна.	100%
30.	НЗДТГ-аас 10 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн УОК-ын 04 дүгээр албан даалгавар, НОК-ын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлийг албан хаагчдад танилцуулж, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Маскаа зүүцгээе, гараа угаая" аянд хамт олноороо нүүр номын хуудсанд тусгай хүрээ бэлтгэн нэгдэж, уриалгыг байгууллагын цахим хуудсанд байршуулав.	100%

31.	Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 381 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан арга хэмжээний тайланг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 197 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.	100%
-----	---	------

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН.
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТНИЙ
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э. ЭНХЗАЯА